



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** СЭ-2022/131-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a></p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс Баланс аудит” ХХК Утас: 77270808 Цахим хаяг: <a href="mailto:nitsbalance@gmail.com">nitsbalance@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.Аудитын тайлан .....	12
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3        16	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4.1 Залруулсан алдаа.....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал



МАНДАЛ СУМЫН ХЭРХ ТОСГОНЫ  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ч.ОДГЭРЭЛ  
ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/131-НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>130,608,334.63</b>	<b>127,172,407.85</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>130,608,334.63</b>	<b>127,172,407.85</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>73,550.00</b>	<b>0.00</b>
35130	Эм боох материал	73,550.00	0.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>130,534,784.63</b>	<b>127,172,407.85</b>
35410	Бичиг хэргийн материал	42,650.00	469,750.00
35420	Аж ахуйн материал	114,098,625.86	110,059,689.96
35470	Бусад хангамжийн материал	16,393,508.77	16,642,967.89
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,342,212,645.56</b>	<b>1,471,931,929.09</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,342,212,645.56</b>	<b>1,471,931,929.09</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,068,508,645.58</b>	<b>1,198,300,429.15</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,021,991,487.93	1,115,378,516.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	-72,580,480.04	-105,514,882.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	8,737,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,562,499.68	0.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	195,807,602.02	120,074,663.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-160,231,165.50	-37,879,737.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	114,282,650.86	95,185,044.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-77,546,764.47	-44,521,558.05
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,885,381.27	30,941,684.51
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,575,023.14	-12,707,436.30
39217	Ном	26,474,956.33	28,606,633.97
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>273,703,999.98</b>	<b>273,631,499.94</b>
39301	Программ хангамж	1,650,000.00	1,490,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-556,250.02	-468,750.06
39303	Бусад биет бус хөрөнгө	272,610,250.00	272,610,250.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,472,820,980.19</b>	<b>1,599,104,336.94</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,472,820,980.19</b>	<b>1,599,104,336.94</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,472,820,980.19</b>	<b>1,599,104,336.94</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	740,475,009.59	740,475,009.59
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-186,566,162.14</b>	<b>-59,573,113.18</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-79,837,314.38	-188,075,491.66
51220	Тайлант үеийн үр дүн	-106,728,847.76	128,502,378.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	918,912,132.74	918,202,440.53
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,472,820,980.19</b>	<b>1,599,104,336.94</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
-----	----------	----------	------------

<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>851,037,456.42</b>	<b>1,013,345,741.78</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>16,867,269.52</b>	<b>183,258,395.43</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>16,867,269.52</b>	<b>183,258,395.43</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - ҮХ	6,407,007.22	171,196,036.31
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - БМ	10,460,262.30	12,062,359.12
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>834,170,186.90</b>	<b>830,087,346.35</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>767,238,100.00</b>	<b>746,135,000.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	767,238,100.00	746,135,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>534,000.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>66,932,086.90</b>	<b>83,418,346.35</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,932,086.90	83,418,346.35
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>891,813,631.13</b>	<b>884,843,363.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>891,813,631.13</b>	<b>884,843,363.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>818,031,540.70</b>	<b>850,856,483.42</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>555,133,440.09</b>	<b>579,524,454.96</b>
210101	Үндсэн цалин	398,065,729.50	389,561,774.96
210102	Нэмэгдэл	115,016,967.64	154,229,270.01
210104	Урамшуулал	42,050,742.95	35,733,409.99
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>69,326,035.48</b>	<b>75,695,183.43</b>
210201	Тэтгэврийн даатгал	47,548,376.51	53,314,241.71
210202	Тэтгэмжийн даатгал	6,403,646.33	5,925,647.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,533,009.66	4,676,677.68
210204	Ажилгүйдлийн даатгал	888,881.39	1,070,783.36
210205	Эрүүл мэндийн даатгал	9,952,121.59	10,707,833.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>61,381,886.90</b>	<b>76,162,746.35</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,040,066.90	3,217,926.35
210302	Түлш, халаалт	58,144,000.00	72,792,000.00
210303	Цэвэр, бохир ус	197,820.00	152,820.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,316,372.25</b>	<b>22,341,705.90</b>
210401	Бичиг хэрэг	270,360.00	450,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,400,000.00	1,487,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	335,900.00	1,641,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	685,000.00	778,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,890,200.89	17,983,185.90
210408	Бараа материал акталсны зардал	3,734,911.36	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,110,570.00</b>	<b>25,646,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	367,770.00	273,550.00
210502	Хоол, хүнс	22,466,600.00	24,872,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	276,200.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,312,800.00</b>	<b>9,860,400.00</b>
210604	Урсгал засвар	14,312,800.00	9,860,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>178,700.00</b>	<b>192,600.00</b>

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	178,700.00	192,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>987,140.00</b>	<b>1,177,590.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	555,140.00	169,590.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	1,008,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>65,284,595.98</b>	<b>60,255,802.78</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	385,350.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	833,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,899,245.98	59,422,552.78
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>73,782,090.43</b>	<b>33,986,879.88</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>250,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	250,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>73,782,090.43</b>	<b>33,736,879.88</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,782,090.43	33,736,879.88
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-40,776,174.71</b>	<b>128,502,378.48</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>65,952,673.05</b>	<b>0.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	65,952,673.05	0.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-106,728,847.76</b>	<b>128,502,378.48</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	740,475,009.59	918,912,132.74	-186,566,162.14	1,472,820,980.19
<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>740,475,009.59</b>	<b>918,912,132.74</b>	<b>-186,566,162.14</b>	<b>1,472,820,980.19</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-1,509,329.52	-1,509,329.52
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>740,475,009.59</b>	<b>918,912,132.74</b>	<b>-188,075,491.66</b>	<b>1,471,311,650.67</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-709,692.21	0.00	-709,692.21
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	128,502,378.48	128,502,378.48

<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>740,475,009.59</b>	<b>918,202,440.53</b>	<b>-59,573,113.18</b>	<b>1,599,104,336.94</b>
--	-----------------------	-----------------------	-----------------------	-------------------------

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>840,265,186.90</b>	<b>832,900,346.35</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>840,265,186.90</b>	<b>832,900,346.35</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>767,238,100.00</b>	<b>746,135,000.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	767,238,100.00	746,135,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>6,095,000.00</b>	<b>3,347,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	534,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,095,000.00	2,813,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>66,932,086.90</b>	<b>83,418,346.35</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,932,086.90	83,418,346.35
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>822,926,036.90</b>	<b>814,954,546.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>822,926,036.90</b>	<b>814,954,546.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>729,146,646.47</b>	<b>762,922,066.47</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>555,133,440.09</b>	<b>581,743,476.69</b>
210101	Үндсэн цалин	405,986,545.88	389,561,774.96
210102	Нэмэгдэл	107,804,440.26	156,448,291.74
210104	Урамшуулал	41,342,453.95	35,733,409.99
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>69,326,035.48</b>	<b>75,695,183.43</b>
210201	Тэтгэврийн даатгал	48,423,120.51	53,314,241.71
210202	Тэтгэмжийн даатгал	5,528,902.33	5,925,647.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,426,679.75	4,676,677.68
210204	Ажилгүйдлийн даатгал	995,211.30	1,070,783.36
210205	Эрүүл мэндийн даатгал	9,952,121.59	10,707,833.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>61,381,886.90</b>	<b>76,162,746.35</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,040,066.90	3,217,926.35
210302	Түлш, халаалт	58,144,000.00	72,792,000.00
210303	Цэвэр, бохир ус	197,820.00	152,820.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,436,700.00</b>	<b>6,080,320.00</b>
210401	Бичиг хэрэг	357,700.00	877,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,300,000.00	1,487,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	335,900.00	1,641,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн	1,085,000.00	778,800.00

	устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,358,100.00	1,294,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>17,737,694.00</b>	<b>10,589,850.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	209,900.00	200,000.00
210502	Хоол, хүнс	8,638,394.00	9,889,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,889,400.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,312,800.00</b>	<b>9,860,400.00</b>
210604	Урсгал засвар	14,312,800.00	9,860,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>178,700.00</b>	<b>192,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	178,700.00	192,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>987,140.00</b>	<b>1,177,590.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	555,140.00	169,590.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	1,008,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,652,250.00</b>	<b>1,419,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	385,350.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,266,900.00	1,419,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>93,779,390.43</b>	<b>52,032,479.88</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,902,300.00</b>	<b>15,482,600.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,102,300.00	14,982,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,095,000.00</b>	<b>2,813,000.00</b>
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,095,000.00	2,813,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>73,782,090.43</b>	<b>33,736,879.88</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	73,782,090.43	33,736,879.88
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>17,339,150.00</b>	<b>17,945,800.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>17,339,150.00</b>	<b>17,945,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>17,339,150.00</b>	<b>17,945,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>17,339,150.00</b>	<b>17,945,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,339,150.00	17,945,800.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-17,339,150.00</b>	<b>-17,945,800.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
-----	----------	------------	-----------	-------	------

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>845,019,700.00</b>	<b>795,816,466.47</b>	<b>49,203,233.53</b>	<b>94.1</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>845,019,700.00</b>	<b>795,816,466.47</b>	<b>49,203,233.53</b>	<b>94.1</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>824,599,100.00</b>	<b>780,333,866.47</b>	<b>44,265,233.53</b>	<b>94.6</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>596,989,400.00</b>	<b>581,743,476.69</b>	<b>15,245,923.31</b>	<b>97.4</b>
210101	Үндсэн цалин	399,313,300.00	389,561,774.96	9,751,525.04	97.5
210102	Нэмэгдэл	161,918,400.00	156,448,291.74	5,470,108.26	96.6
210104	Урамшуулал	35,757,700.00	35,733,409.99	24,290.01	99.9
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>80,432,500.00</b>	<b>75,695,183.43</b>	<b>4,737,316.57</b>	<b>94.1</b>
210201	Тэтгэврийн даатгал	55,952,800.00	53,314,241.71	2,638,558.29	95.2
210202	Тэтгэмжийн даатгал	6,119,900.00	5,925,647.10	194,252.90	96.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,896,000.00	4,676,677.68	219,322.32	95.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,224,000.00	1,070,783.36	153,216.64	87.4
210205	Эрүүл мэндийн даатгал	12,239,800.00	10,707,833.58	1,531,966.42	87.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>91,629,100.00</b>	<b>76,162,746.35</b>	<b>15,466,353.65</b>	<b>83.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,422,300.00	3,217,926.35	5,204,373.65	38.2
210302	Түлш, халаалт	80,881,600.00	72,792,000.00	8,089,600.00	90.00
210303	Цэвэр, бохир ус	2,325,200.00	152,820.00	2,172,380.00	6.5
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,206,100.00</b>	<b>5,892,120.00</b>	<b>313,980.00</b>	<b>94.9</b>
210401	Бичиг хэрэг	581,900.00	581,900.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,487,700.00	1,487,120.00	580.00	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,896,000.00	1,641,800.00	254,200.00	86.5
210404	Ном, хэвлэл	345,800.00	345,800.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	540,800.00	59,200.00	90.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,294,700.00	1,294,700.00	0.00	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>18,047,600.00</b>	<b>10,589,850.00</b>	<b>7,457,750.00</b>	<b>58.6</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	207,400.00	200,000.00	7,400.00	96.4
210502	Хоол, хүнс	17,340,200.00	9,889,850.00	7,450,350.00	57.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>27,460,400.00</b>	<b>27,460,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,600,000.00	9,600,000.00	0.00	100.0
210602	Тавилга	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	9,860,400.00	9,860,400.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>258,100.00</b>	<b>192,600.00</b>	<b>65,500.00</b>	<b>74.6</b>
210702	Дотоод албан	258,100.00	192,600.00	65,500.00	74.6

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны Ерөнхий боловсролын дунд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ТОМИЛОЛТ				
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,156,000.00</b>	<b>1,177,590.00</b>	<b>978,410.00</b>	<b>54.6</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	169,590.00	330,410.00	33.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,656,000.00	1,008,000.00	648,000.00	60.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,419,900.00</b>	<b>1,419,900.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,419,900.00	1,419,900.00	0.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,420,600.00</b>	<b>15,482,600.00</b>	<b>4,938,000.00</b>	<b>75.8</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>20,420,600.00</b>	<b>15,482,600.00</b>	<b>4,938,000.00</b>	<b>75.8</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,920,600.00	14,982,600.00	4,938,000.00	75.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>845,019,700.00</b>	<b>795,816,466.47</b>	<b>49,203,233.53</b>	<b>94.1</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>746,135,000.00</b>	<b>712,398,120.12</b>	<b>33,736,879.88</b>	<b>95.4</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	746,135,000.00	712,398,120.12	33,736,879.88	95.4
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>98,884,700.00</b>	<b>83,418,346.35</b>	<b>15,466,353.65</b>	<b>84.3</b>
320001	Орон нутгийн төсвөөс	98,884,700.00	83,418,346.35	15,466,353.65	84.3
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>634.00</b>	<b>662.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	0.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00	0.00	0.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>52.00</b>	<b>52.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
620001	Удирдах ажилтан	4.00	4.00	0.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00	0.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	0.00	0.00
620004	Гэрээт ажилтан	0.00	0.00	0.00	0.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,347,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,347,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>534,000.00</b>
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>534,000.00</b>
210401	Бичиг хэрэг	296,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	238,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,813,000.00</b>
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,813,000.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,813,000.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,347,000.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,347,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	534,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,813,000.00

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургууль гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитыг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн аудитор Г.Хүрэл хариуцаж хэрэгжүүлэв. Аудитын анхан шатны чанарын хяналтыг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар гүйцэтгэв.

Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургууль 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Хичээл сургуулийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад бүх талтай хамтран ажиллах” гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны зорилгыг хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах боломж нөхцөлийг бүрдүүлж, сурлагын хоцрогдлыг арилгахад чиглэсэн ажлуудыг үр дүнтэй зохион байгуулж, сургууль завсардалтгүй сургах;
- Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах, цахим болон даалгаврын санд баяжилт хийж, ашиглах;
- Багш бүр нөхцөл байдлаас үл хамаарч ажлын байран дээрээ заах арга, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/
- ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургууль 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 891,813.6 мянган төгрөгийн 2.0 хувиар буюу 17,836.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14,269.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 126,283.4 мянган төгрөгөөр өссөн ба өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийн дүн материаллаг хэмжээний өөрчлөлттэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	130,608.3	127,172.4	(3,435.9)
Үндсэн хөрөнгө	1,342,212.6	1,471,931.9	129,719.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,472,820.9</b>	<b>1,599,104.3</b>	<b>126,283.4</b>
Богино хугацаат өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,472,820.9	1,599,104.3	126,283.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,472,820.9</b>	<b>1,599,104.3</b>	<b>126,283.4</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 127,172.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,435.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 40,762.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, хандиваар 12,062.4 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авч бүртгэсэн ба 56,260.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,673,024.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 8,240.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 17,945.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 94,993.3 мянган төгрөгийн дээврийн засварыг бүртгэн, БШУЯ-наас 4,657.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,400.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,785.9 мянган төгрөгийн ном сурах бичгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн, аймгийн ОНӨГ-ын шийдвэрийн дагуу 44,388.7 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн үнийг бууруулж, сумын ИТХ-ын 2021 оны 139 дүгээр тогтоолоор 86,635.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,599,104.3 мянган төгрөг болж, 126,283.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,013,345.7 мянган төгрөг болж өмнөх оноос 166,308.3 мянган төгрөгөөр буюу 19.1 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон орон нутгийн төсвийн санхүүжилт тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардал 884,843.4 мянган төгрөг болж өмнөх оноос 6,970.2 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 976,194.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг 273,831.4 мянган төгрөгөөр бууруулж, 702,362.8 мянган төгрөгөөр баталсан байна. 2021 оны төсөвт хийсэн өөрчлөлтөөр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 43,772.2 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 98,884.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, 845,019.7 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн боловсролын хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 845,019.7 мянган төгрөг батлагдсанаас 746,135.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 98,884.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 746,135.0 мянган төгрөг төгрөг, орон нутгийн төсвөөс 83,418.3 мянган төгрөгийн нийт 829,553.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн, урсгал үйл ажиллагааны зардалд 795,816.5 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 33,736.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **795,816.5** мянган төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардал 19,983.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 15,466.4 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 313.9 мянган төгрөгөөр, нормативт зардал 7,457.8 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 65.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 978.4 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 4,938.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд БСГ-аас 534.0 мянган төгрөгийн, түрээсийн номны 2,813.0 мянган төгрөгийн нийт 3,347.0 мянган төгрөгийн орлого хүлээн авч, хангамж, бараа материалын зардалд 534.0 мянган төгрөгийг зарцуулж, 2,813.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1.БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай ” тушаалын хоёрдугаар хавсралт “*Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам*”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Хэрх тосгоны ерөнхий боловсролын сургуулийн тайлант оны үйл ажиллагаанд 845,019.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 795,816.5 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 5.9 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт-3 Өмнөх оны аудитын зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1		1			-	100.0
Албан шаардлага	1	606.6	1	606.6	-	-	100.0
Нийт	<b>2</b>	<b>606.6</b>	<b>2</b>	<b>606.6</b>			

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан

горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

#### **4.Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 8,024.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 499.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,219.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 5,305.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өглөө.

##### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланд хангамж, бараа материалыг 249.9 мянган төгрөгөөр илүү, урсгал шилжүүлгийн зардлыг 250.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн 499.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

##### **4.2 Албан шаардлага**

1. Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр НДШ-ийн зөрүү гэх үндэслэлээр тайлант оны батлагдсан төсвөөс 2,219.0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “*Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.3 дахь “*бүх өр төлбөр*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг тухай бүр нь үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

##### **4.3 Зөвлөмж**

1. ***Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал***

###### ***1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд***

1.1.1 *Илрүүлэлт:* Тайлант онд 5,305.6 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 *Өгсөн зөвлөмж:* Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын*

нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хэрх тосгоны ЕБС	4	8,024.5	2	499.9			1	2,219.0	1	5,305.6